



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 348

Улаанбаатар хот


“Бичил санхүүгийн салбарын 2012-2016 онд хэрэгжүүлэх
үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги” батлах тухай 117 дугаар тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтад хамаарах чиглэлээр “Бичил санхүүгийн салбарын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. “Бичил санхүүгийн салбарын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлуудыг Ажлын албаны жил бүрийн төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтийг ханган ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001881

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР

“САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ”-Т ТУСГАГДСАН ЧИГЛЭЛЭЭР
БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРТ 2012-2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2012 он

1. Оршил

- 1.1. "Бичил санхүүгийн салбарын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө" боловсруулах үндэслэл, зорилго, ач холбогдол.....2-3

2. Бичил санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтад хамаарах салбарын эрх зүйн орчин, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- 2.1. Банк бус санхүүгийн байгууллага4-5
- 2.2. Хадгаламж, зээлийн хоршоо5-8
- 2.3. Зээлийн батлан даалтын сан8-9
- 2.4. Товч дүгнэлт9-10

3. Хорооны хяналт, зохицуулалтад хамаарах бичил санхүүгийн салбарын статистик үзүүлэлт

- 3.1. Банк бус санхүүгийн байгууллага11-13
- 3.2. Хадгаламж, зээлийн хоршоо13-15
- 3.3. Товч дүгнэлт15-16

4. Бичил санхүүгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө

- 4.1. Бичил санхүүгийн салбарын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад харгалзсан хүчин зүйл.....17-18
- 4.2. Бичил санхүүгийн салбарын үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх хөтөлбөр
- 4.2.1. Бичил санхүүгийн стратегийн зорилт 18
- 4.2.2. Хорооны стратегийн зорилго болон бичил санхүүгийн салбарын зорилтод хүрэхэд чиглэгдсэн хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагаа19-22
- 4.2.3. Хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэх хугацаа, холбоос, Хорооны стратегийн зорилго, салбарын зорилтод нийцэж байгаа байдал.....23-28
- 4.3. Хэрэгжүүлэх хугацаа 29
- 4.4. Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт 29
- 4.5. Санхүүжилт 29

1. Оршил

1.1. “Бичил санхүүгийн салбарт 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах үндэслэл, зорилго, ач холбогдол

Хөгжиж буй улс орнуудын хувьд ядуу, орлого багатай иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх боломжийг бүрдүүлэх, үйл ажиллагаагаа эхлүүлэх, өргөжүүлэхэд нь туслах, бичил зээл олгох, олсон орлогын тодорхой хэсгийг ирээдүйдээ хэрэглэх, хадгаламж хэлбэрээр хуримтлуулах дадалд сургах, эрүүл мэнд, амь насаа даатгуулах, төлбөр, тооцоог шуурхай, зардал багатайгаар гүйцэтгэх боломжийг олгох бичил санхүүгийн¹ дэд салбарыг хөгжүүлэх замаар ядуурлыг бууруулах нь шалгарсан аргуудын нэг болжээ.

2011 оны байдлаар Монгол орны ядуурлын түвшин 29.8 хувь байгаа нь бичил санхүүгийн салбарыг хөгжүүлэх замаар ядуу, орлого багатай иргэдэд хүрч үйлчлэх зайлшгүй шаардлага байгааг илтгэж байна.

Энэхүү шаардлагыг хангах үүднээс Санхүүгийн зохицуулах хорооноос бичил санхүүгийн салбарт дунд хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсрууллаа.

Хууль, эрх зүйн үндэслэл:

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 117 дугаар тогтоолын хавсралтаар “Санхүүгийн зохицуулах хорооны 2012-2016 оны үйл ажиллагааны стратеги”-ийг баталж, салбар тус бүрийн чиглэлээр 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, 2012 оны 3 дугаар улиралд багтаан тус Хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын албанд даалгасан.

Практик үндэслэл:

Бичил санхүүгийн салбарыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, хөгжлийн бодлого боловсруулах, олон улсын тэргүүн туршлагыг салбарт хэрэгжүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар ядуу, бага орлоготой иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг зайлшгүй боловсруулах шаардлага тулгарч байна.

Зорилго:

¹ Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан холбогдох хуулийг хэрэгжүүлэлтийн хангуулахтай холбогдуулан банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодынүйл ажллагаатай холбогдсон харилцааг хамруулсан болно.

Байгууллагын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дунд хугацаанд бичил санхүүгийн салбарт авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох зорилготой.

Ач холбогдол:

Салбарын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах нь дунд хугацаанд хэрэгжүүлэх ажлаа төлөвлөх, ажлын уялдаа холбоог хангах, хэрэгжилтэд тухай бүр хяналт тавих боломжийг бүрдүүлэх, байгууллагын зорилгыг биелүүлэхэд ач холбогдол бүхий үйл явц болно.

2. Бичил санхүүгийн салбарын хяналт зохицуулалтад хамаарах эрх зүйн орчин, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

2.1. Банк бус санхүүгийн байгууллага

Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хүрээнд 2006 оноос хойш дангаараа болон Монголбанктай хамтран баталсан нэр бүхий 22 журам, заавар хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Эдгээр журмын хүрээнд банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, банк бус санхүүгийн итгэлцлийн, хөрөнгө оруулалтын, цахим мөнгөний үйлчилгээний, зээлийн батлан даалтын үйлчилгээний, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлэх, банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, тэдгээрийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх зэрэг харилцааг зохицуулсан.

Гадаад валютын арилжааг цэгцлэх зорилгоор Хорооны 2009 оны 28 дугаар тогтоолоор валют солих цэгийн зөвшөөрөл авсан хуулийн этгээдүүдийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалтад хамруулан, тусгай зөвшөөрөл олгон, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж байна.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын үйл ажиллагаанд нэн тааламжтай орчинг бий болгох, санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх замаар санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлагыг олон улсын жишигт нийцүүлэх, зохицуулалтын уян хатан бодлого баримтлах зорилгоор Хорооноос Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн бариулахаар УИХ-ын гишүүдэд хүргүүлж байсан бөгөөд одоогоор уг хуулийн төслийг дахин нягтлан, боловсруулалтыг гүйцэтгэн ажиллаж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын зохицуулалтын эрх зүйн орчин тодорхой болж, тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжих, санхүүгийн зуучлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэхийг зохицуулалтын бодлогоор дэмжих, түүнд тавигдах шаардлага, хориглох зүйл болон хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хууль тогтоомж зөрчигчдөд авах албадлагын арга хэмжээ, ногдуулах захиргааны шийтгэлийн хэмжээг бодитой тогтоосноор тухайн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулж, цаашдын тогтвортой хөгжилд ач холбогдолтой арга хэмжээ болох юм.

Үүний дүнд санхүүгийн зах зээлийн банк бус санхүүгийн салбарыг хөгжүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болж, үйл ажиллагаа эрхлэх таатай орчинг бүрдүүлсэнээр

хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, салбарын хөгжлийн эрчимжилтийг бататгах, төрөөс баримталж буй мөнгөний бодлогыг зөв зүйтэй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний нөлөө үзүүлж, улмаар нийгэм, эдийн засагт банк бус санхүүгийн байгууллагуудын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх юм.

Банк бус санхүүгийн байгууллагуудын тогтвортой хөгжлийг хангах, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, сургалт, семинар хийх, мэдээлэл солилцох зэрэг чиглэлээр хамтран ажиллаж, санамж бичгийн хэрэгжилтийг дүгнэн ажиллаж байна.

Бичил санхүүгийн хөгжлийн сангаас олгодог бөөний зээлд банк бус санхүүгийн байгууллагуудыг хамруулан Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийг тухай бүр гаргаж, дээрх бөөний зээлд хамрагдах банк бус санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарлаа хандуулан ажилласан.

2.2. Хадгаламж, зээлийн хоршоо

Хадгаламж, зээлийн хоршоод нь өнгөрсөн хугацаанд Хоршооны тухай хууль болон Хорооноос баталсан 4 журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд хадгаламж, зээлийн хоршоодыг нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдуулан олон улсын хоршооллын зарчмын дагуу хөгжих бололцоог бүрдүүлэх, санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, бусад санхүүгийн байгууллагуудтай өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хямралын үед гарсан, нийгмийг хамарсан муу үр дагавар бүхий үйлдлүүдийг дахин гаргахгүй байх зэрэг бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодоос ялгарах онцлогт тохирсон зохицуулалт бүхий Хадгаламж, зээлийн хоршооны тухай бие даасан хуулийн төслийг боловсруулсан ба улмаар Монгол Улсын Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлагдан, мөн оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс мөрдөгдөн хэрэгжиж эхэлсэн.

Хорооны зүгээс тус хуульд нийцүүлэн хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг хуульд заасан болон олон улсын зарчимд нийцүүлэн хөгжүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2012 онд Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам, Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил үйлчилгээний журам, Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос үзүүлэх тогтворжилтын үйлчилгээний журам болон хадгаламж, зээлийн хоршоодын эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалтыг тус тус шинээр, Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт

тавих журам, Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар, Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох арга, аргачлалд өөрчлөлт оруулах тухай баримт бичиг болон Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн заавар, нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлуулан мөрдүүлж ажиллаж байна.

Мөн хадгаламж, зээлийн хоршоодыг олон улсын хоршооллын зарчмын дагуу тогтвортой хөгжүүлэх, чадавхийг сайжруулах, төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоотой байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд Хадгаламж, зээлийн хоршооны хуулийг хэрэгжүүлэх, хадгаламж, зээлийн хоршоодын удирдлага, ажилтнуудын чадварыг дээшлүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллаж, санамж бичгийн хэрэгжилтийг дүгнэж ажиллаж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль нь 2012 оны 12 дугаар сарын 22-ноос эхлэн мөрдөгдөж эхэлсэн бөгөөд хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган ажиллаж байгаа ба төлөвлөгөөт ажлын хүрээнд дор дурдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- Хуулийг олшруулан орон нутагт үйл ажиллагаа явуулж хадгаламж, зээлийн хоршоо, дарга, удирдлагуудад зориулсан аргачилсан зөвлөмжийг тусгай зөвшөөрөлтэй бүхий л хадгаламж, зээлийн хоршоод, бүх гишүүдийн хурлаа хуралдуулаагүй, дүрэм, журмаа шинэ хуульд нийцүүлэн шинэчлээгүй хадгаламж, зээлийн хоршоод, сонгуульт ажилтнууд нь хуулийн шаардлагад нийцээгүй хадгаламж, зээлийн хоршоод тус бүрт албан бичиг хүргүүлж, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар тодорхой чиглэлүүдээр үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулан ажилласан;
- Хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл, хууль хэрэгжүүлэх талаар хамран ажиллах хүсэлтийг Хорооны 2012 оны 01 дүгээр сард албан бичгээр хүргүүлсний дүнд тус байгууллагаас бүх аймгуудын Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нарт 2012 оны 02 дугаар сард албан бичиг илгээж хоршооны оноосон нэрний ард “ХЗХ” гэсэн тэмдэглэгээ хийх, тухайн хоршооноос холбогдох бичиг баримтыг хүлээн авч улсын бүртгэлд бүртгэхийг үүрэг болгосон;
- Хуульд заасны дагуу шинээр тусгай зөвшөөрөл хүсэх хадгаламж, зээлийн хоршоодыг улсын бүртгэлд бүртгэхдээ чирэгдэл учруулахгүй байх, цаашид тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон, татан буугдсан зэрэг бүртгэлтэй холбогдуулан

хамтарч ажиллах талаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт албан бичиг хүргүүлж 2002 хойш улсын бүртгэлд бүртгүүлэн хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байсан хадгаламж, зээлийн хоршоодоос татан буугдсан, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон, тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж буй хадгаламж, зээлийн хоршоодын судалгааг аймаг, хот, дүүргээр шинэчлэн гаргаж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын судалгаатай зэрэгцүүлэн шалган, Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хүргүүлэн ажилласан;

- Хадгаламж, зээлийн үйл ажиллагаатай холбогдсон шинээр 4, нэмэлт өөрчлөлт бүхий 1, шинэчлэн 2 журмыг шинэчлэн батлуулсан ба энэхүү ажлын хүрээнд, тухайлбал, "Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн заавар, нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал"-ыг Сангийн сайд, СЗХ-ны даргын 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 232/216 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан;
- Хуультай холбогдуулан гаргасан УИХ-ын тогтоолын хэрэгжилт, УИХ-ын Байнгын хороодын хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн тайланг 3, 6, 10 дугаар саруудад Хорооны АА-нд хүргүүлсэн;
- Баянхонгор, Төв, Хэнтий, Өвөрхангай, Булган, Дундговь аймгуудад хийсэн газар дээрх үзлэг, ХЗХ-дын Зүүн болон Баруун бүсийн чуулга уулзалтуудаар ХЗХ-дын удирдлага, гишүүд болон олон нийтэд хуулийг сурталчлах, тэдгээрийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд зориулан мэдээлэл өгч, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Хорооноос баталсан холбогдох журмуудын эмхтгэл, гарын авлагуудыг ХЗХ-д болон иргэдэд тараах ажлыг зохион байгуулсан;
- Бичил санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийг жилийн тайлангийн нэгтгэл, танилцуулгаар олон нийтэд мэдээлсэн бөгөөд холбогдох сургалт, семинар, уулзалтуудад тухай бүр мэдээллийг мэргэжлийн холбоо, зохицуулалтын байгууллага, иргэдэд хүргэхэд анхааран ажилласан бөгөөд энэхүү бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тусгай зөвшөөрөлтэй холбогдон Хорооноос гаргасан шийдвэрүүдийн талаар тухай бүр Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газарт албан бичгээр мэдээллийг хүргүүлэх, Хорооны цахим хуудас, өдөр тутмын сониноор мэдээлэх зэргээр ажилласан;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг олон нийтэд сурталчлах, хэрэгжүүлэх, холбогдох мэдээллийг хүргүүлэх зорилгоор 5 удаагийн ярилцлагыг олон нийтийн хэвлэлээр нийтлүүлж, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын

үндэсний холбоо болон Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвийн удирдлага, төлөөлөлтэй уулзах уулзалтуудыг тухай бүр зохион байгуулж, мэдээлэл өгч ажилласан

- Хууль, журмын эмхтгэлийн эхийг бэлтгэн 300 ширхэгийг “Мөнхийн үсэг” хэвлэлийн компаниар хэвлүүлсэн.

Түүнчлэн хөдөөгийн бичил санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, гишүүд, ажилтнуудын чадварыг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулах зорилгоор Хасбанктай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.

Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвөөс зохион байгуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын ажилтнуудад зориулсан сургалтад тухай бүр Хорооны хянан шалгагч нар оролцон журам, зааврыг танилцуулах болон хуулийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах талаар сургалтыг хийж ажиллалаа.

2.3. Зээлийн батлан даалтын сан

Зээлийн батлан даалтын үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, эрсдэлээс сэргийлэх, хяналт тавих зорилгоор Хорооны 2010 оны 225 дугаар тогтоолоор “Зээлийн батлан даалтын үйлчилгээний зохицуулалтын түр журам”-ыг баталсан.

Улмаар Зээлийн батлан даалтын сангийн тухай тухай хуулийг 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр УИХ-аас баталсанаар зээлийн барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд сангаас зээлийн 60 хүртэл хувьд нь батлан даалт гаргах эрх зүйн орчинг бүрдүүлснээр жижиг, дунд үйлдвэрийг дэмжих боломжийг бүрдүүлсэн.

Уг хуулиар Хороо нь Зээлийн батлан даалтын сангийн дүрмийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох ба Сангийн өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавихаар заасан.

Хуулийн хэрэгжилтийг түргэтгэх үүднээс Хорооноос зээлийн батлан даалтын сангийн дүрмийн төслийн загварыг боловсруулж Зээлийн батлан даалтын санг үүсгэн байгуулах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж, Зээлийн батлан даалтын сангийн үүсгэн байгуулагчдын шийдвэрээр батлагдсан дүрмийг Хорооны 2012 оны 11 дүгээр сарын хуралдаанаар хэлэлцэн баталснаар Зээлийн батлан даалтын санг үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа эрхлэн явуулж эхэлсэн.

Мөн хуулиар хүлээсэн эрх, үүргийн хүрээнд “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хяналт тавих журам”-ыг Хорооны 2012 оны 11 дүгээр сарын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Түүнчлэн уг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сангийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Банкуудын холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай уулзах уулзалтыг 2012 оны 8 дугаар сарын 22-ны өдөр санаачлан зохион байгуулан ажилласны сацуу 2012 оны төсвийн тодотгол болон 2013 оны төсөвт зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны санхүүжилтэд хөрөнгө суулгах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар Монгол улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд, Эдийн засгийн болон Төсвийн байнгын хорооны дарга нарт албан бичиг хүргүүлэн ажилласны үр дүнд 2012 оны төсөвт 5.0 тэрбум төгрөгийг суулгасан.

2.4. Товч дүгнэлт

Банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн зах зээлд эзлэх байр суурь, иргэд, харилцагчдад хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрийн гүйцэтгэх үүргийн хувьд тэдгээрийн үндсэн үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа байгаад анхаарлаа хандуулж, хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа, санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэхэд журам, заавар зэрэг зохицуулалтын баримт бичгийн хувьд боловсронгуй болгох, арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлэх нь чухал байна.

Мөн тэдгээрийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг оновчтой, уян хатан байлгах, тусгай зөвшөөрөл олгох, түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг аль болох хялбарчлах арга замыг эрэлхийлэн ажиллах нь зүйтэй. Түүнчлэн тодорхой үе шаттайгаар Санхүүгийн зохицуулах хорооны зарим эрх, үүргийг салбарын мэргэжлийн холбоод руу шилжүүлэх арга хэмжээ авах, эрх зүйн зохицуулалтыг нь бий болгох нь цаашдын зорилтын нэг болж байна.

Шинээр батлагдсан Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн салбарын үйл ажиллагааг хуульд заасан болон олон улсын зарчимд нийцүүлэн хөгжүүлж, гишүүдэд хүргэх санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, идэвхитэй үйл ажиллагаа, хариуцлагыг сайжруулахтай холбогдуулан журам, заавруудыг шинэчлэх, шинээр батлуулж мөрдүүлэх шаардлагатай байна.

Ялангуяа орон нутаг дахь жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх, тэдгээрийн бизнесийн үйл ажиллагаа, орон нутгийн хөгжлийг хангахад орон нутгийн онцлогтой уялдуулан хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих төрөөс баримтлах бодлогын тодорхойлоход Хороо эн тэргүүнд анхаарах нь зүйтэй.


Хууль батлагдан, мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан 2012-оос 2015 онд хэрэгжүүлэх Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр Азийн хөгжлийн банк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлж буй “Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд гүйцэтгэх хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох, хадгаламж, зээлийн хоршоод болон бусад санхүүгийн байгууллагуудын чадавхи, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлыг үр дүнтэй, чанартай, хүртээмжтэйгээр зохион байгуулах нь Санхүүгийн зохицуулах хорооны цаашдын үйл ажиллагааны чухал хэсэг юм.

Хорооны хяналт, зохицуулалтад хамаарх салбар, цаашилбал нийт улс орны хэмжээнд бичил санхүүгийн салбарын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд төрийн мөнгөний бодлого болон үндсэн чиглэлд тодорхой асуудлуудыг тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоодоор дамжуулан төсөл, хөтөлбөрийн зээл олгох, зээлийг хүүг бууруулах, бичил санхүүгийн салбар дахь зээлийн батлан даалтын орчныг сайжруулах зэрэг асуудлаар төрийн бусад эрх бүхий байгууллагуудтай бодлогын түвшинд нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

3. Хорооны хяналт, зохицуулалтад хамаарах бичил санхүүгийн салбарын статистик үзүүлэлт


3.1. Банк бус санхүүгийн байгууллага

Монгол улсын санхүүгийн салбарт гарсан дэвшилтэт өөрчлөлтүүдийн нэг нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд банкны зарим үйл ажиллагааг хүргэх, тэр болгон хүрч чаддаггүй бичил зээлийн томоохон орон зайг нөхөх, санхүүгийн зуучлалын хүрээг өргөжүүлэх зорилгоор банк бус санхүүгийн байгууллагууд 1999 оноос эхлэн шинээр үүсч хөгжиж ирсэн явдал юм. 2011 оны байдлаар Хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр 195 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна. Салбарын актив жил ирэх тутам өсч байсан ба 2011 оны байдлаар уг салбарын нийт активын хэмжээ 2006 оны үзүүлэлтээс 3 дахин, олгосон зээлийн багцын хэмжээ 3.9 дахин тус өссөн байна. Нийт активт эзлэх зээлийн багцын хэмжээ 43.8-57.9 хувь байгаа нь салбарын үндсэн үйл ажиллагааны нэр төрөл нь зээлийн үйл ажиллагаа болохыг харуулж байна.



Монголбанкны 2005 онд гаргасан дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх тухай шийдвэрийг хангаж ажиллах боломжгүй шалтгаанаар 2007 онд банк бус санхүүгийн байгууллагууд татан буугдах үзэгдэл гарснаар нийт активын хэмжээ буурч байсан бол түүнээс хойшхи хугацаанд Хорооноос валют солих цэгийн үйл ажиллагааг төрөөс зохицуулахтай холбогдуулан хууль тогтоомжийн хүрээнд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хэлбэрээр зохицуулсан, банк бус санхүүгийн байгууллагуудын дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх тухай шийдвэр гаргасан зэрэгтэй холбогдуулан нийт хөрөнгийн хэмжээ жил ирэх тутамд нэмэгдсээр ирсэн ба 2011 оны байдлаар салбарын нийт актив нь банкны салбарын нийт активын 2.2 хувийг эзэлж байна.

Зээлийн чанарын хувьд 2006-2011 онуудад нийт зээлийн багцын 1.3-6.1 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй байна.




Дээрх онуудын үзүүлэлтийн дунджаар тооцвол нийт зээлийн багц дахь 90.6 хувийг хэвийн, 3.7 хувийг хугацаа хэтэрсэн, 5.7 хувийг чанаргүй зээл эзэлж байна.


Нийт эх үүсвэрийн бүтцийн хувьд сүүлийн 6 жилийн байдлаар 69.0-77.6 хувийг эзэмшигчдийн өмч, 22.4-31.0 хувийг нийт өр төлбөр эзэлж байна. 2011 оны байдлаар нийт банк бус санхүүгийн байгууллагуудын эзэмшигчдийн өмч 138.2 тэрбумд хүрсэн нь банкны салбарын 20.4 хувийг эзэлж байна.



Нийт өр төлбөр 2006 оноос 2011 оныг хүртэл 3.1 дахин өссөн байх ба 2011 оны байдлаар нийт өр төлбөрийн 77.7 хувийг банк, санхүүгийн байгууллагад төлөх зээл, хувийг итгэлцлийн өглөг, төслийн зээлийн санхүүжилт эзэлж байна. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн байгууллагын тоо сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор салбарын нийт итгэлцлийн өглөгийн хэмжээ өсөх хандлагатай байна.




Нийт эзэмшигчдийн өмч 2006 оноос 2011 оныг хүртэл 2.9 дахин өссөн байна. 2006 онд хувь нийлүүлэгчдийн оруулсан хувьцаат капиталын хэмжээ 91.2 хувийг эзэлж байсан бол 2011 оны 84.3 хувь болж буурсан байх ба хуримтлагдсан ашиг 4.0 байснаас 10.6 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.



Хувьцаат капиталын хэмжээ 116.5 тэрбумд хүрсэн нь банкны салбарын 44.1 хувийг эзэлж байна. Түүнчлэн хөрөнгө оруулагчдын зүгээс “Базел 2”-д заасан зарчмын дагуу хоёрдогч өглөгөөр мөнгөн хөрөнгө байршуулах замаар эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх байдал мөн л өсөх хандлагатай байна.

2006-2011 онд нийт орлого 5.1, нийт зардал 4.5 хувиар тус тус өссөн бол хуримтлагдсан ашиг 8.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




Нийт орлогод эзлэх хуримтлагдсан ашиг 2006 онд 14.3 хувь байгаа нь сүүлийн 6 жилийн хугацааны хамгийн бага үзүүлэлт бол, 2011 онд 24.6 хувьд хүрсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

3.2. Хадгаламж, зээлийн хоршоо

2011 оны байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр 162 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр ХЗХ-дын 71 буюу 43.8


хувь нь Улаанбаатар хотод, 91 буюу 56.2 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.



Тайлант онууд дахь хадгаламж, зээлийн хоршоодын тооны өөрчлөлттэй холбоотойгоор гишүүдийн тоонд дараах өөрчлөлтүүд орсон байна.



Нийт хөрөнгийн хэмжээ жил ирэх тутамд нэмэгдсэн байх ба 2011 оны байдлаар нийт активын хэмжээ 2006 оныхоос 4 дахин өссөн байна. 2011 онд нийт активын 67.0 хувийг гишүүдэд олгосон зээлийн багцын үлдэгдэл, нийт эх үүсвэрийн 70.8 хувийг гишүүдээс татсан хадгаламж, 13.6 хувийг гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 7.8 хувийг хоршоологчдын өмч тус тус эзэлж байгаа бөгөөд салбарын нийт актив нь банкны салбарын нийт активын 0.7 хувийг эзэлж байна.




Зээлийн чанарын хувьд 2006-2011 онуудад нийт зээлийн багцын 0.8-2.6 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй байна.



Дээрх онуудын үзүүлэлтийн дунджаар тооцвол нийт зээлийн багц дахь 85.1 хувийг хэвийн, 7.8 хувийг хугацаа хэтэрсэн, 7.1 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна.

2006-2011 онд нийт орлого 2.1, нийт зардал 1.7 хувиар тус тус өссөн бол хуримтлагдсан ашиг 2006 онд 0.2 хувийн алдагдалтай, 2011 онд 2.2 тэрбум төгрөгийн ашигтай байна.



Хуримтлагдсан ашиг сүүлийн 5 жилийн дунджаар нийт орлогын 15.5 хувийг эзэлж байна.

3.3. Товч дүгнэлт

Банк бус санхүүгийн байгууллагууд нь ихэвчлэн банкны зээлдэгчийн шалгуурыг хангаагүй зээлдэгчдэд зээл олгодог ба 2011 оны байдлаар 2.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь банкны салбартай зэрэгцэн зээлдэгчдийн зээлийн эрэлтийг хангаж ажиллах боломжтой болохыг харуулж байна. Энэ боломжийн хүрээнд хөрөнгө оруулагчид банк бус санхүүгийн байгууллага байгуулан, зээлийн үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой байдаг. Гэхдээ салбарын активын бүтцийг судалж үзвэл активын 31 хувь нь мөнгөн хөрөнгө байгаа нь бизнесийн эргэлтэд оруулах нөөцөө хангалттай ашиглаж чадахгүй байгааг илтгэж байна. Иймээс сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг орлого оруулдаг активт байршуулж, санхүүгийн бусад үйлчилгээг үзүүлж ашгаа нэмэгдүүлэх боломж байна.

2011 оны байдлаарх 195 банк бус санхүүгийн байгууллагын 153 нь зээлийн үйл ажиллагааг эрхэлдэг нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан бусад үйл ажиллагааг эрхлэх сонирхол, туршлага, зах зээлийн боломж хомс байгаатай холбоотой юм.

Монгол Улсын хүн амын 103 хүн тутмын 1 нь хадгаламж, зээлийн хоршооны гишүүнээр бүртгэлтэй байна. Уг салбарын аалбарын активын бүтцийг судалж үзвэл активын 29 хувь нь мөнгөн хөрөнгө байгаа нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангахуйц хэмжээнээс илүү гарсан нөөцөө хангалттай ашиглаж чадахгүй байгааг илтгэж байна. Салбарын нийт хадгаламжийн 48.3 хувь, оруулсан хувь хөрөнгийн 24.6 хувь нь 1 хадгаламж, зээлийн хоршоонд төвлөрч байгаа нь хэт төвлөрлийг үүсгэсэн үзүүлэлттэй байна. Нийт хадгаламж, зээлийн хоршоодын 50 хувийг 50 хүртэл сая төгрөгийн активтай хадгаламж, зээлийн хоршоод эзэлж байна. Үүнээс харахад, тухайн хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээг нэмэгдүүлэх замаар тэдгээр хадгаламж, зээлийн хоршоодын тогтвортой үйл ажиллагааг хангахад Хороо нэн анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

4. Бичил санхүүгийн салбарын үйл ажиллагааны төлөвлөгөө

4.1. Бичил санхүүгийн салбарын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад харгалзсан хүчин зүйлс

2006 оноос 2011 он хүртэлх хугацаанд Хорооноос хэрэгжүүлсэн зохицуулалтын арга хэмжээ, салбарын санхүүгийн үзүүлэлтийг үндэслэн үр дүнг үнэлэн дараагийн 5 жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хүрэх үр дүнг төсөөлсөн болно.

Салбарын хөгжилд макро эдийн засгийн хүчин зүйлс голлон нөлөөлөх бөгөөд Хорооны зүгээс салбарыг хөгжүүлэх, зохицуулах, хянах үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар хувь нэмрээ оруулах юм.

Хорооны 2012-2016 оны стратеги төлөвлөгөөнд “Байгууллагын стратеги”-ийг Зохицуулах үйл ажиллагааны стратеги (1); Туслах үйл ажиллагааны стратеги (2) гэж ангилан авч үзсэн бөгөөд Бичил санхүүгийн салбар нь Зохицуулах үйл ажиллагааны стратегит хамаарахаар томъёологдсон.

Түүнчлэн Хороо “Эрхэм зорилго”-оо “Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлэх” гэж томъёолсон бөгөөд харин “Стратегийн зорилго”-ыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Монгол улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, тогтвортой хөгжүүлэх;
2. Санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох;
3. Харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах (туслах), хадгаламж эзэмшигчдийн эрхийг хамгаалах (үндсэн);
4. Олон нийтийг сургах, санхүүгийн зах зээлийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах.

Мөн Хорооны үйл ажиллагаанд баримталбал зохих дараах 4 зарчмыг тодорхойлж өгсөн. Үүнд:

- Хараат бус байх;
- Итгэл хүлээсэн байх;
- Хүндэтгэл хүлээсэн байх;
- Ил тод байх.

Өнгөрсөн жилүүдэд бичил санхүүгийн зах зээл дэлхийн хэмжээнд нэлээд далайцтайгаар хөгжиж ирсэн. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, шинэ технологи бий болгох, хөгжүүлэх, үйлдвэрлэх, бичил болон том бизнесийн хоорондын холбоог

бэхжүүлэх замаар ажлын шинэ байрыг нэмэгдүүлэх, шинээр бий болгох явдал чухал байр суурийг эзэлсээр байна.

Монгол улсын бичил санхүүгийн салбарыг хөгжүүлэх нь бичил санхүүгийн системийн тухай олон нийтийн боловсролын түвшин, мэдлэг, ойлголт хэр байгаагаас ихээхэн хамаарч байна.

Монгол улсын тухайд нийт иргэдийн 40 хувь эдгээр асуудлын талаар мэдлэг мэдээлэл муутай байгаа нь төрийн болон төрийн бус байгууллагын зүгээс хууль эрх зүйн үндсийг сайжруулж боловсронгуй болгох, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдсэн өргөн далайцтай арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

Монгол улсын санхүүгийн зах зээлийн эрх зүйн зохицуулалтын хувьд Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтдаа улсынхаа санхүүгийн системийг хянан зохицуулах үүрэг хүлээдэг бөгөөд 2010 оны 01 дүгээр сард шинэчлэн найруулагдсан батлагдсан Банкны тухай хуулиар Хороо нь санхүүгийн салбарт нэгдсэн зохицуулалт хийх холбогдох журам, зааврыг Монголбанкт хамтран ажиллах зайлшгүй бодит шаардлагатай байгаа билээ.

Мөн түүнчлэн Хороо нь Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албатай байнгын нягт холбоотой ажиллах явдал нь өнөөгийн хууль тогтоомжийн хүлээсэн үүргийн нэг болоод байна.

Хорооны стратеги төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Бичил санхүүгийн газрын ажилтнуудын ур чадвар, чадавхийг сайжруулах, зохицуулах үйл ажиллагааг үр дүнтэй, үр нөлөө бүхий явуулахад энэхүү хөтөлбөр нь томоохон хувь нэмрээ оруулах учиртай юм.

4.2. Бичил санхүүгийн салбарын үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх хөтөлбөр

4.2.1. Бичил санхүүгийн стратегийн зорилт

Хорооны 2012-2016 оны үйл ажиллагааны стратегийн баримт бичигт бичил санхүүгийн салбарт дараах зорилтот ажлыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон. Үүнд:

- А. Хүртээмжтэй санхүүгийн салбарын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бичил санхүүгийн зохицуулалтын загвар боловсруулах;**
- В. Бичил санхүүгийн газрын чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааг зохицуулдаг хууль эрх зүйн актуудыг боловсронгуй болгох;**
- С. Эрх шилжүүлэх боломж, нөхцлийн талаар үнэлгээ хийх (зарим эрх үүргийг шилжүүлэх боломжтой этгээд болон холбогдох асуудлыг хамарсан).**

4.2.2. *Хорооны стратегийн зорилго болон бичил санхүүгийн салбарын зорилтод хүрэхэд чиглэгдсэн хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагаа*

Бичил санхүүгийн газрын зүгээс дээр дурдсан Хорооны стратегийн зорилго болон уг баримт бичигт бичил санхүүгийн салбарын хувьд тодорхойлсон зорилтот хүрэхийн тулд дараах үндсэн гурван хөтөлбөрийн хүрээнд доорхи ажлуудыг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

Хөтөлбөр 1: Банк бус санхүүгийн байгууллагын салбарт хэрэгжүүлэх хөтөлбөр

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.1. Хөгжиж буй улс орнуудын эрх зүйн орчны талаар судалгаа хийх, туршлагыг нь судлах, өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэглэх арга зам, бодлого боловсруулах;
- 1.2. Холбогдох судалгааны үндсэн дээр банк бус санхүүгийн байгууллагуудын чадамж, салбарын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн салбарт үзүүлэх нөлөөллийг сайжруулах талаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;
- 1.3. Банк бус санхүүгийн байгууллагуудын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар судалгаа дүгнэлт гаргах, санал санаачлагыг бодлогоор дэмжих, эрх зүйн зохицуулалтыг бий болгох, хэрэгжилтийг хангуулах;
- 1.4. Банк бус санхүүгийн байгууллагуудын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, чадамжийг сайжруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай төслийг УИХ-аар батлуулах;
- 1.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуульд нийцүүлэн шаардлагатай журам, заавар, аргачлалуудыг шинээр боловсруулан, батлуулах;
- 1.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа журам, заавар, аргачлалуудад нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан, батлуулах;
- 1.7. Шаардлагатай бусад бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах арга хэмжээ авах;
- 1.8. Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /Тогтоол 69, МУЗГ, 2011.03.09./-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, батлуулах, хэрэгжүүлэх;
- 1.9. Салбарын эрсдэлийн удирдлагыг бий болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар салбарын байгууллагуудын хөгжлийг олон

улсын чиг хандлагад ойртуулах талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт боловсруулах;

- 1.10. Бусад улс орнуудтай харьцуулах замаар салбарын төлөв байдал болон сайжруулах арга замуудын талаарх судалгаанд үндэслэн салбарын эрсдэлийг үнэлэх, удирдах, санхүүгийн хямралыг хохирол багатай даван туулах боломж, нөхцлийн талаар дүгнэлт гаргах;
- 1.11. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх талаарх судалгаа хийх, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;
- 1.12. Төрийн бус байгууллагуудтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах хүрээнд зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг зохион байгуулах /МББСБХ/;
- 1.13. Салбарын байгууллагуудын ажилтнуудын ур чадвар болон иргэдийн санхүүгийн боловсрол нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгааны төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- 1.14. Салбарын байгууллагуудын ажилтнуудад зориулж мөрдөгдөж буй хууль тогтоомжийн эмхтгэл, иргэдэд зориулсан гарын авлага бэлтгэх.

Хөтөлбөр 2: Хадгаламж, зээлийн хоршооны салбарт хэрэгжүүлэх хөтөлбөр

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.1. Бусад улс орнуудын эрх зүйн орчны талаар судалгаа хийх, туршлагыг нь судлах, өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэглэх арга зам, бодлогын баримт бичиг боловсруулах;
- 2.2. Холбогдох судалгааны үндсэн дээр хадгаламж, зээлийн хоршоодын чадавхи, салбарын үйлчилгээний цар хүрээ, бичил санхүүгийн салбарт хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэх талаар бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;
- 2.3. Хадгаламж, зээлийн хоршоодын эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах, журам, зааврыг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;
- 2.4. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн шаардлагатай журам, заавар, аргачлалуудыг шинээр боловсруулан, батлуулах;
- 2.5. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн мөрдөгдөж байгаа журам, заавар, аргачлалуудад нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан, батлуулах;
- 2.6. Шаардлагатай бусад бодлогын баримт бичиг боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах арга хэмжээ авах;

- 2.7. Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /Тогтоол 69, МУЗГ, 2011.03.09./-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, батлуулах, хэрэгжүүлэх;
- 2.8. Хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, чадавхийн үнэлгээ тогтоох арга аргачлалын бий болгох, үнэлгээ өгөх, зэрэглэлийн системийг нэвтрүүлэх, сайжруулах;
- 2.9. Салбарын эрсдэлийн удирдлагыг бий болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хадгаламж, зээлийн хоршоодын хөгжлийг олон улсын чиг хандлагад ойртуулах талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт боловсруулах;
- 2.10. Бусад улс орнуудад хэрэгжүүлж буй Хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар судалгаа хийж, хадгаламж, зээлийн хоршооны салбарын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авах;
- 2.11. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх талаарх судалгаа хийх, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;
- 2.12. Төрийн бус байгууллагуудтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах хүрээнд зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг зохион байгуулах /МХЗХҮХ, МХСМТ/
- 2.13. Хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааг чадавхижуулах ажлын хүрээнд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоо, Монголын хоршоологчдын сургалт, мэдээллийн төв зэрэг холбогдох мэргэжлийн төрийн бус байгууллагуудын техникийн шинэчлэлийг хийхэд төслийн хүрээнд туслалцаа үзүүлэх;
- 2.14. Төрийн бус байгууллагуудын сургагч багш нарыг бэлтгэж, тус байгууллагуудаар дамжуулан чадавхижуулах сургалт зохион байгуулах /МХЗХҮХ, МХСМТ/;
- 2.15. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулиар хүлээсэн МХЗХҮХ-ны чиг үүргийн хүрээнд хамрагдах тогтворжилтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх, оновчтой зохион байгуулах ажилд бодлогоор дэмжих;
- 2.16. Хадгаламж, зээлийн хоршоодын ажилтнуудын чадвар болон иргэдийн санхүүгийн боловсрол нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгааны төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- 2.17. Хадгаламж, зээлийн хоршоодод зориулж мөрдөгдөж буй хууль тогтоомжийн эмхтгэл, иргэдэд зориулсан гарын авлага бэлтгэх;

- 2.18. Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй Азийн хөгжлийн банкны төслийн олон улсын болон үндэсний зөвлөх, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоо, Монголын хоршоологчдын сургалт, мэдээллийн төвтэй хамтран хадгаламж, зээлийн хоршоодын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх сургалтын модулийг боловсронгуй болгох, сургагч багш нар бэлтгэх, сургалт, зөвлөгөө өгөх;
- 2.19. Хадгаламж зээлийн хоршоод, тэдгээрийн үйл ажиллагаа, ач холбогдлын талаарх олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийх, иргэдийн санхүүгийн боловсролын талаар олон улсын байгууллагуудын хийсэн судалгаан дээр үндэслэн төслийн зөвлөхүүдтэй хамтран иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох, үнэлгээ хийх;
- 2.20. Үнэлгээг үндэслэн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх хөтөлбөр, программыг зөвлөхүүдтэй хамтран боловсруулж, олон нийтийн хэвлэл мэдээлэлээр түгээх, үр дүнг нь тооцох.

Хөтөлбөр 3: Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулиар хүлээсэн эрх, үүргийн хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр

- 3.1. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан холбогдох журам, зааврыг боловсруулах;
- 3.2. Шаардлагатай бусад бодлогын баримт бичиг боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах арга хэмжээ авах;
- 3.3. Зээлийн батлан даалтын сангийн хяналт, зохицуулалтын механизмыг бүрдүүлэх, сайжруулах, гарч болзошгүй эрсдэлд үнэлгээ, дүгнэлт өгөх;
- 3.4. Зээлийн батлан даалтын сангийн тогтвортой хөгжлийг хангах, үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахтай холбогдуулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай харилцан хамтран ажиллах, хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах.

4.2.3. Хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэх хугацаа, холбоос, Хорооны стратегийн зорилго, салбарын зорилтод нийцэж байгаа байдал

Бичил санхүүгийн газрын зүгээс салбарын 2012-2016 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь дээр дурдсан Хорооны стратегийн зорилго болон уг баримт бичигт бичил санхүүгийн салбарын хувьд тодорхойлсон зорилтуудад хэрхэн нийцэж байгаа, дотоод бүтцийн хувьд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд Хорооны газар, нэгжүүдийн оролцоо, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнг тооцох хугацааг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

№	Хийгдэх ажлууд	Холбоос	Хэрэгжүүлэх хугацаа					Хорооны стратегийн зорилго				Бичил санхүүгийн зорилт		
			2012	2013	2014	2015	2016	1	2	3	4	A	B	C
1. Банк бус санхүүгийн байгууллагын салбарт хэрэгжүүлэх хөтөлбөр														
1.1	Хөгжиж буй улс орнуудын эрх зүйн орчны талаар судалгаа хийх, туршлагыг нь судлах, өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэглэх арга зам, бодлого боловсруулах	ЭЗХ бусад газар		X	X	X	X	X	X	X	X	X	X	X
1.2	Холбогдох судалгааны үндсэн дээр банк бус санхүүгийн байгууллагуудын чадамж, салбарын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн салбарт үзүүлэх нөлөөллийг сайжруулах талаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангуулах	ЭЗХ бусад газар		X	X	X	X	X	X	X	X	X	X	X
1.3	Банк бус санхүүгийн байгууллагуудын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар судалгаа дүгнэлт гаргах, санал санаачлагыг бодлогоор дэмжих, эрх зүйн зохицуулалтыг бий болгох, хэрэгжилтийг хангуулах	ЭЗХ. ЭҮССГБҮГ	X	X	X	X	X	X	X			X	X	
1.4	Банк бус санхүүгийн байгууллагуудын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, чадамжийг сайжруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай төслийг УИХ-аар батлуулах	ЭЗХ		X				X	X	X		X	X	

1.5	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуульд нийцүүлэн шаардлагатай журам, заавар, аргачлалуудыг шинээр боловсруулан, батлуулах	ЭЗХ		X	X	X	X	X	X	X	X		X	
1.6	Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа журам, заавар, аргачлалуудад нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан, батлуулах	ЭЗХ	X	X	X	X	X	X	X	X			X	
1.7	Шаардлагатай бусад бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах арга хэмжээ авах	ЭЗХ бусад газар	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X
1.8	Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /Тогтоол 69, МУЗГ, 2011.03.09./-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, батлуулах, хэрэгжүүлэх	КЗХХА, ҮЦГ, ДГ, ТГ, ЭЗХ		X				X	X			X	X	
1.9	Салбарын эрсдэлийн удирдлагыг бий болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар салбарын байгууллагуудын хөгжлийг олон улсын чиг хандлагад ойртуулах талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт боловсруулах	ЭҮССШБҮГ, ҮЦГ, ДГ	X	X	X	X	X	X	X	X		X	X	
1.10	Бусад улс орнуудтай харьцуулах замаар салбарын төлөв байдал болон сайжруулах арга замуудын талаарх судалгаанд үндэслэн салбарын эрсдэлийг үнэлэх, удирдах, санхүүгийн хямралыг хохирол багатай даван туулах боломж, нөхцлийн талаар дүгнэлт гаргах	ЭҮССШБҮГ, ҮЦГ, ДГ		X	X	X	X	X	X	X		X	X	
1.11	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх талаарх судалгаа хийх, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах	ЭҮССШБҮГ, ҮЦГ, ДГ		X	X	X	X	X	X	X		X	X	
1.12	Төрийн бус байгууллагуудтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах хүрээнд зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг зохион байгуулах /МБСБХ/	-		X	X	X	X	X	X	X			X	X

1.13	Салбарын байгууллагуудын ажилтнуудын ур чадвар болон иргэдийн санхүүгийн боловсрол нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгааны төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	ТГ		X	X	X	X			X	X	X	X	
1.14	Салбарын байгууллагуудын ажилтнуудад зориулж мөрдөгдөж буй хууль тогтоомжийн эмхтгэл, иргэдэд зориулсан гарын авлага бэлтгэх	ТГ		X			X			X	X			
2. Хадгаламж, зээлийн хоршооны салбарт хэрэгжүүлэх хөтөлбөр														
2.1	Бусад улс орнуудын эрх зүйн орчны талаар судалгаа хийх, туршлага судлах, өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэглэх арга зам, бодлогын баримт бичиг боловсруулах	ЭЗХ бусад газар		X	X	X	X	X	X	X	X	X	X	X
2.2	Холбогдох судалгааны үндсэн дээр хадгаламж, зээлийн хоршоодын чадавхи, салбарын үйлчилгээний цар хүрээ, бичил санхүүгийн салбарт хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэх талаар бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах	ЭЗХ бусад газар		X	X	X	X	X	X	X	X	X	X	X
2.3	Хадгаламж, зээлийн хоршоодын эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах, журам, зааврыг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах	ЭЗХ. ЭҮССГБҮГ	X	X	X	X	X	X				X	X	
2.4	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн шаардлагатай журам, заавар, аргачлалуудыг шинээр боловсруулан, батлуулах	ЭЗХ	X	X				X	X	X	X		X	
2.5	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн мөрдөгдөж байгаа журам, заавар, аргачлалуудад нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан, батлуулах	ЭЗХ	X	X	X	X	X	X	X	X			X	
2.6	Шаардлагатай бусад бодлогын баримт бичиг боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах арга хэмжээ авах	ЭЗХ бусад газар		X	X	X	X	X	X	X	X	X	X	X

2.7	Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /Тогтоол 69, МУЗГ, 2011.03.09./-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, батлуулах, хэрэгжүүлэх	КЗХХА, ҮЦГ, ДГ, ТГ, ЭЗХ		X				X	X			X	X	
2.8	Хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, зэрэглэл тогтоох арга аргачлалын бий болгох, үнэлгээ өгөх, зэрэглэлийн системийг нэвтрүүлэх, сайжруулах	АХБ-ны төслийн нэгж	X	X	X	X	X	X	X	X		X	X	
2.9	Салбарын эрсдэлийн удирдлагыг бий болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хадгаламж, зээлийн хоршоодын хөгжлийг олон улсын чиг хандлагад ойртуулах талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт боловсруулах	ЭҮССШБҮГ, ҮЦГ, ДГ		X	X	X	X	X	X	X		X	X	
2.10	Бусад улс орнуудад хэрэгжүүлж буй Хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар судалгаа хийж, хадгаламж, зээлийн хоршооны салбарын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авах	ЭҮССШБҮГ, ДГ		X	X	X		X	X	X		X	X	
2.11	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх талаарх судалгаа хийх, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах	ЭҮССШБҮГ, ҮЦГ, ДГ		X	X	X	X	X	X	X		X	X	
2.12	Төрийн бус байгууллагуудтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах хүрээнд зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг зохион байгуулах /МХЗХҮХ, МХСМТ/	ЭЗХ	X	X	X	X		X	X	X			X	X
2.13	Хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааг чадавхижуулах ажлын хүрээнд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоо, Монголын хоршоологчдын сургалт, мэдээллийн төв зэрэг холбогдох мэргэжлийн төрийн бус байгууллагуудын техникийн шинэчлэлийг хийхэд төслийн хүрээнд туслалцаа үзүүлэх	АХБ-ны төслийн нэгж	X	X						X	X			X

2.14	Төрийн бус байгууллагуудын сургагч багш нарыг бэлтгэж, тус байгууллагуудаар дамжуулан чадавхижуулах сургалт зохион байгуулах /МХЗХҮХ, МХСМТ/	АХБ-ны төслийн нэгж		X	X	X				X	X			X
2.15	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулиар хүлээсэн МХЗХҮХ-ны чиг үүргийн хүрээнд хамрагдах тогтворжилтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх, оновчтой зохион байгуулах ажилд бодлогоор дэмжих	ЭЗХ	X	X				X	X	X			X	X
2.16	Хадгаламж, зээлийн хоршоодын ажилтнуудын чадвар болон иргэдийн санхүүгийн боловсрол нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгааны төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	ТГ		X	X	X	X			X	X	X	X	
2.17	Хадгаламж, зээлийн хоршоодод зориулж мөрдөгдөж буй хууль тогтоомжийн эмхтгэл, иргэдэд зориулсан гарын авлага бэлтгэх	ТГ	X	X			X			X	X			
2.18	Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй Азийн хөгжлийн банкны төслийн олон улсын болон үндэсний зөвлөх, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо, Монголын хоршоологчдын сургалт, мэдээллийн төвтэй хамтран хадгаламж, зээлийн хоршоодын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх сургалтын модулийг боловсронгуй болгох, сургагч багш нар бэлтгэх, сургалт, зөвлөгөө өгөх	АХБ-ны төслийн ба нэгж		X	X				X	X	X	X		
2.19	Хадгаламж зээлийн хоршоод, тэдгээрийн үйл ажиллагаа, ач холбогдлын талаарх олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийх, иргэдийн санхүүгийн боловсролын талаар олон улсын байгууллагуудын хийсэн судалгаан дээр үндэслэн төслийн зөвлөхүүдтэй хамтран иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох, үнэлгээ хийх	АХБ-ны төслийн нэгж	X	X					X	X	X	X		

2.20	Үнэлгээг үндэслэн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх хөтөлбөр, программыг зөвлөхүүдтэй хамтран боловсруулж, олон нийтийн хэвлэл мэдээлэлээр түгээх, үр дүнг нь тооцох	АХБ-ны төслийн нэгж		X	X				X		X	X		
3. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулиар хүлээсэн эрх, үүргийн хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр														
3.1	Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан холбогдох журам, зааврыг боловсруулах	ТГ, ЭЗХ	X					X	X	X			X	
3.2	Шаардлагатай бусад бодлогын баримт бичиг боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах арга хэмжээ авах	ЭЗХ бусад газар		X	X	X	X	X	X	X	X	X	X	X
3.3	Зээлийн батлан даалтын сангийн хяналт, зохицуулалтын механизмыг бүрдүүлэх, сайжруулах, гарч болзошгүй эрсдэлд үнэлгээ, дүгнэлт өгөх	ЭҮССШБҮГ	X	X	X	X	X	X	X	X		X	X	
3.4	Зээлийн батлан даалтын сангийн тогтвортой хөгжлийг хангах, үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахтай холбогдуулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай харилцан хамтран ажиллах, хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах	ЭЗХ		X	X	X	X	X	X	X		X	X	

4.3. Хэрэгжүүлэх хугацаа

2012-2016 он хүртэл 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх ба жил бүрийн төлөвлөгөөнд хөтөлбөр бүрийн хүрээнд хийгдвэл зохих төлөвлөгөөт ажлуудыг нарийвчлан тусгана.

4.4. Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратегид тодорхойлсон бичил санхүүгийн салбарт хамаарсан зорилго хангагдсан байна.

4.5. Санхүүжилт

Улсын төсвийн хөрөнгө /зохицуулалтын үйлчилгээний хөлс/ болон хандивлагчдын хөрөнгөөр дээрх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.